



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20 19 он 05
сарын 30 өдөр

Дугаар ЗГ-1/79

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
М.ЭНХБОЛД ТАНАА

Санал өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасныг тус тус үндэслэн Жамъянсүрэнгийн Батсуурийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын үүрэгт ажлаас огцруулах тухай асуудлыг хуульд заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчтэй зөвшилцөж Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Уг асуудлыг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Монгол Улсын Ерөнхий сайд



Ж.ЭРДЭНЭБАТ



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

2017 оны 05 сарын 30 өдөр

Дугаар Е/03

Төрийн ордон, Улаанбаатар хот


МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ЖАРГАЛТУЛГЫН ЭРДЭНЭБАТ ТАНАА

Санал хүргүүлэх тухай

Танай 2017 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн “Санал хүргүүлэх тухай” ЗГ-1/78 дугаар албан бичигтэй танилцлаа.

Уг асуудлыг Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хуульд заасан эрхийн хүрээнд шийдвэрлэх нь зүйтэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ



ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ

0000000034

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Засгийн газрын гишүүн эрхэлсэн асуудлын хүрээнд төрийн бодлого боловсруулж, хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийг биелүүлэх ажлыг Засгийн газрын өмнөөс эрхлэн гүйцэтгэж, зохих хүрээ, салбарын хөгжил, ажил хэргийн байдал, үр дүнг Ерөнхий сайд, улмаар Улсын Их Хурлын өмнө дангаар, харин Засгийн газрын үйл ажиллагааны талаар хамтын хариуцлага тус тус хүлээнэ” гэж заасан. Гэтэл Засгийн газрын гишүүн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ж.Батсуурь нь ажиллах хугацаандаа эрхлэх асуудлын хүрээний салбарыг нэгдсэн удирдлагаар хангах, төрийн бодлого боловсруулах, хууль тогтоомжийг биелүүлэх үүргээ хангалтгүй биелүүлж, албан үүрэгтээ хариуцлагагүй хандсан гэж үзэж байна.

Өнгөрсөн хугацаанд боловсролын салбарт дараахь зохисгүй үйлдлүүд гарсан нь тухайн салбарыг нэгдсэн удирдлагаар хангах үүрэгтэй сайдын үйл ажиллагаатай шууд холбоотой гэж үзэж байна. Тухайлбал:

- Нийслэлийн 29 дүгээр сургуулийн сурагчид сурч, боловсрох эрх нь зөрчигдөж, уг сургуулийн багш нар сурагчдын эрхийг зөрчиж байгаа талаар эсэргүүцлийн жагсаал зохион байгуулсан;

- Нийслэлийн 116 дугаар сургуулийн ахлах ангийн сурагчид сургуулийн захирал, удирдлагууд сурагчдыг доромжилдог, үзэл бодлыг нь сонсдоггүй, зарим багш нарын мэргэжлийн ур чадвар муу гэх үндэслэлээр хичээл хаялт зарласан;

- 2017 оны 5 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулагдсан 12 дугаар ангийн математикийн хичээлийн шалгалтын сэдэв, даалгавар шалгалт эхлэхээс өмнө задарсан.

Засгийн газрын гишүүн-Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ж.Батсуурь нь дээр дурдсан сургуулиудад үүссэн асуудлыг шийдвэрлэх талаар үр дүнтэй арга хэмжээ аваагүй, одоог хүртэл асуудлыг шийдвэрлэж, үүссэн нөхцөл байдлыг арилгаагүйн зэрэгцээ төгсөлтийн шалгалттай холбоотой оновчгүй шийдвэр гаргасан. Энэхүү шийдвэрийн дагуу 12 дугаар ангийн математикийн хичээлийн шалгалтыг дахин явуулж, олон мянган сурагчид, эцэг, эхчүүдэд чирэгдэл учруулж, бухимдлыг төрүүлсэн.

Засгийн газрын гишүүн-Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ж.Батсуурь нь эрхэлсэн салбарын хүрээний хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, дүрэм, журмыг боловсруулах, цаг алдалгүй батлах, зөрчлийг арилгах талаар зохих арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй зэргээр албан үүргээ хангалтгүй биелүүлсэн байна.

Түүнчлэн 2017 оны 1 дүгээр сард Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны газар, хэлтсийн дарга нараас Төрийн нарийн бичгийн даргатай хамтран ажиллах боломжгүй талаархи өргөх бичгийг Ерөнхий сайдад ирүүлж байсан. Үүнтэй холбогдуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Ажлын хэсэг гарган тус яаманд

үүссэн асуудлыг шалгаж үзэхэд яамны удирдлагууд хоорондоо таарч ажиллаагүй, яамны аппарат хуваагдаж хоорондоо зөрчилдсөнөөс болж бодлого боловсруулах, хэрэгжилтийг хангах ажил цалгардсан байдалтай байсан. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас тодорхой зөвлөмж, дүгнэлт гаргасан. Монгол Улсын Ерөнхий сайд миний зүгээс Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ж.Батсуурьт дүгнэлтэд дурдсан алдаа дутагдлыг арилгах, яамны үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр үүрэг, даалгавар өгсөн боловч тэдгээрийг хэрэгжүүлэх тал дээр анхаарч ажиллаагүй бөгөөд яаманд үүссэн нөхцөл байдлыг арилгах, яамны хэвийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Засгийн газрын гишүүн-Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ж.Батсуурь нь хууль тогтоомжоор олгогдсон эрх, үүргийн хүрээнд салбарын бодлого болон яамны өдөр тутмын үйл ажиллагааг нэгтгэн удирдаж чадаагүй бөгөөд Засгийн газрын итгэлийг хүлээн ажиллаж чадахгүй болохоо харуулсан.

Иймд Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Ерөнхий сайд миний бие Засгийн газрын гишүүн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ж.Батсуурийг огцруулах саналыг хуульд заасан журмын дагуу гаргаж байна.

---000---

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ..

Улаанбаатар
хот

Монгол Улсын Засгийн газрын
гишүүнийг огцруулах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 38.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Жамъянсүрэнгийн Батсуурийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын үүрэгт ажлаас огцруулсугай.

2.Энэ тогтоолыг 2017 оны ... дугаар сарын ...ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ